**"Тайваний Олон улсын хүүхдийн кино урлагийн фестиваль"-д**
**оролцох хүсэлт гаргах тухай мэдээлэл**

Мэдээлэл бэлтгэсэн огноо：2019 оны 5-р сар

| Кино урлагийн наадмын нэр, зохиогдох хугацаа, холбоо барих цахим хуудас | Кино наадам, үзэсгэлэнгийн бүртгэлийн мэдээлэл | Зохион байгуулагч байгууллага болон холбоо барих мэдээлэл |
|---|---|---|
| " 9 дэхь удаагийн Тайваний Олон улсын хүүхдийн кино урлагийн фестиваль"<br>(Taiwan International Children's Film Festival)<br>2020 оны 4-р сар<br>http://www.ticff.org.tw/en/ | **Нэг.** Бүртгэлийн хугацаа: 2019 оны 5-р сарын 6-наас 9-р сарын 6-ны өдөр<br>Бүртгүүлэх журам /Англи хувилбар/ доорхи цахим холбоосоор зочлон уншиж танилцах.<br>http://www.ticff.org.tw/en/competition/Submission<br><br>**Хоёр.** Бүртгэл хийлгэхэд тавигдах шаардлага<br>1/ 12-аас доош насны хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр, кино бүтээл байх шаардлагатай.<br>2/ 2017 оны 9-р сарын 1-ний өдрөөс 2019 оны 9-р сарын 6-ны хооронд бүтээгдэж дууссан бүтээл байх (бүртгэлийн хугацаанаас өмнө бүтээгдэж дууссан байх)<br><br>**Гурав.** Оролцох бүтээлийн төрөл<br>**※「Тэмцээн」( Competition)**<br>1.Богино хэмжээний уран сайхны кино：5-40 минут<br>2.Бүрэн хэмжээний уран сайхны кино：40 минутаас дээш<br>3.Богино хэмжээний хүүхэлдэйн кино：1-40 минут<br>4.Бүрэн хэмжээний хүүхэлдэйн кино：40 минутаас дээш<br>5.Телевиз, интернетийн цуврал нэвтрүүлэг: 1-60 минут<br>(Тайлбар: Телевиз/ интернетийн цуврал нэвтрүүлэг, эдгээрээс нэг төрлийн бүтээлийг сонгон, тэмцээнд оролцох боломжтой.)<br><br>**※「Ажиглалтын буюу туршилтын бүтээл」(тэмцээний бус төрөл) ( Non-Competition)**<br>1. Баримтат кино：10-100 минут<br>2. Бяцхан найруулагч：1-30минут (6-14 насны хүүхэд багачууд ганцаарчлан болон багаараа оролцох боломжтой)<br>**Дөрөв.** Бүртгүүлэх хэлбэр<br>/1/ FilmFreeway эсвэл /2/ онлайнаар | "Тайваний Олон улсын хүүхдийн кино урлагийн фестиваль" /Олон нийтийн телевизийн соёлын арга хэмжээний сан ТББ/<br>Tel ： 886-2-2633-2000 #1881 эсвэл #1051<br>Fax：886-2-2630-1895<br>Email：<br>ticff@mail.pts.org.tw<br>ticff.ptsoffice@gmail.com<br>Website：<br>http://www.ticff.org.tw |

| | | |
|---|---|---|
| | (http://www.ticff.org.tw/en/) цахим хуудаснаа зочлон, бүртгэлийн мэдээллээ оруулан, зааварын дагуу трейлэрийн цахим холбоос болон киноны файлаа байршуулж, бүртгэлийн хураамжаа төлнө. Баталгаажуулалтын захидал хүлээн авсны дараа тэмцээнд бүргтүүлэх үйл явц дуусна.<br>(**Тайлбар**：Бүтээл тус бүр дээр бүртгэлийн маягт бөглөх шаардлагатай ба зөвхөн нэг ангилалд бүртгүүлэх боломжтой. Бүтээлийн агуулга нь бүртгэлийн төрлөөс зөрүүтэй байгаа тохиолдолд сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй болно. Энэ тохиолдолд зохион байгуулагч байгууллагаас тусгайлан мэдэгдэхгүй болно.)<br>**1. FilmFreeway**：Юуны өмнө энэхүү цахим порталаар зочлон бүтээлийн мэдээллийг бүртгүүлнэ. Үүний дараа бүтээлээ https://filmfreeway.com/TICFF руу илгээнэ.<br>2. Цахим сүлжээгээр бүртгүүлэх /Англи хэлээр/: Тайваний Олон улсын хүүхдийн кино урлагийн фестивалын албан ёсны цахим хуудас болох http://www.ticff.org.tw/competition/Register цахим хуудсаар зочлон бүртгэл хийлгэсний дараа цахимаар бүртгэлийн хураамжаа төлнө. Бүртгэл хийлгэх үйл явц дууссаны дараа бүртгэл хийлгэсэн хүн нь бүртгэлийн системээс цахим шуудангийн хаягаар бүртгэлийн код бүхий “Бүртгэл баталгаажуулах захидал” хүлээн авна. (Нэг бүртгэлийн маягтаар нэг бүртгэлийн дугаар хүлээн авна).<br>3.Зөвхөн ажиглалтын буюу туршилтын бүтээлийн төрөлд бүртгүүлж байгаа нөхцөлд цахим шуудангаар зохион байгуулагч байгууллагатай холбогдон, бүтээлээ илгээнэ.<br>ticff@mail.pts.org.tw<br>ticff.ptsoffice@gmail.com<br><br>**Тав.** Туршилтын журмаар үзэх бүтээлийн видео болон аудио файлд тавигдах шаардлага<br>1.Бүрэн хэмжээний бүтээл байх шаардлагатай ба бүтээлийн агуулга кино фестиваль дээр тавигдах агуулгатай ижил байх<br>2. Файлын формат: .mov, .mp4 эсвэл m4v，стерио | |

| | | |
|---|---|---|
| | дугаралттай байна (stereo audio)<br>3. Код：h.264<br>4. Видео бүтээлийн хэмжээ：SD 640x480 эсвэл 720x480，HD 1920x1080 эсвэл 720x1280<br>5.Бүтээлийн видео болон аудио файл салангад, тасалдсан байж болохгүй. Тухайн файл 2 гегабайтаас бага хэмжээтэй байвал WeTransfer ашиглан сүлжээнд байршуулах боломжтой. Тухайн файл 2 гегабайтаас том хэмжээтэй байгаа тохиолдолд өөр аргаар сүлжээнд байршуулна. /Төлбөр төлөх шаардлагатай байж магадгүй./<br>6. Хадмал орчуулга буюу титр：Хэрэв тухайн оролцож буй туршилтын журмаар үзэж сонирхох кино бүтээл нь Англи эсвэл Хятад хэл дээр бол хадмал орчуулга хийх шаардлагагүй. Өөр хэл дээр байгаа кино бүтээлийн хувьд Англи хэл дээрхи хадмал орчуулга хийх шаардлагатай.<br>**Зургаа.** Шагнал урамшуулал：<br>1.Шилдэг богино хэмжээний уран сайхны киноны шагнал<br>2.Шилдэг бүрэн хэмжээний уран сайхны киноны шагнал<br>3.Шилдэг богино хэмжээний хүүхэлдэйн киноны шагнал<br>4.Шилдэг бүрэн хэмжээний хүүхэлдэйн киноны шагнал<br>5.Шилдэг телевиз/ интернетийн цуврал нэвтрүүлэгийн шагнал<br>6. Шүүгчдийн багийн тусгай шагнал<br>7. Тайваний шагнал<br>8.Үзэгчдийн саналаар шалгаруулсан шагнал<br>Эхний 1-ээс 7-р төрлийн шагналыг 3.500 ам.доллар ба цом дагалдана. Үзэгчдийн саналаар шалгаруулсан шагнал урмашуулалаар цом олгогдоно./Нэмэлт тайлбар: Зөвхөн тэмцээний төрөлд бүртгүүлсэн бүтээлүүд нь дээрхи шагналаас хүртэх боломжтой./ | |